



**НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
УЛААНБААТАР НЭГТГЭЛ ОНӨААТҮГ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2016 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/60

Улаанбаатар хот

Тамирчдын өдрийг тэмдэглэх тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн 100 дугаар тогтоолоор батлагдсан "Нийтийн үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл" ОНӨААТҮГ-ын дүрмийн 6.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тамирчдын өдөр-2016" баярыг байгууллагын ажилтнуудын дунд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Дээрх баярыг тэмдэглэх ажлын хүрээнд харьяа байгууллагуудын дунд зохион байгуулдаг тэмцээнүүдэд спортын амжилт гаргасан ажилтнуудад дурсгалын зүйл гардуулахад шаардагдах 200 000 /Хоёр зуун мянган/ төгрөгийг нийгмийн арга хэмжээний зардлаас тооцон гаргахыг Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч /Д.Мөнх-Эрдэнэ/-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн удирдлагын хэлтсийн дарга /Б.Мөнх-Оргил/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  Б.ГАНЗОРИГ



ТТ38526 № 8115125